



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 83

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.6.4. дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. "Мандалын гэгээ Хот тохижуулах газар" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үл хөдлөх хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 44,632,872.71 /дөчин дөрвөн сая зургаан зуун гучин хоёр мянга найман зуун далан хоёр төгрөг далан нэгэн мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй, 36,152,138.50 /гучин зургаан сая нэг зуун тавин хоёр мянга нэг зуун гучин найман төгрөг тавин мөнгө/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 2 нэр төрлийн хөрөнгийг хавсралтын дагуу акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Бүтээн байгуулалт хийх талбайд байршуулсан сурталчилгааны 3 ширхэг самбарын зээмшигчийг тодруулж Мандалговь хотын өрөнхий төлөвлөгөөтэй уялдуулан байршуулах эсэх асуудлыг шийдвэрлэж, иргэн аж ахуй нэгжид хяналт тавин ажиллахыг ы Сайнцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Т.Батжаргал)-д даалгасугай.

3. "Мандалын гэгээ Хот тохижуулах газар" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал (Д.Очбадрах)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1 Актлах хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор акталж, акталснаас гарсан материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх, бүтээн байгуулалтын талбайд байх модонд гэмтэл учруулахгүй байх, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулжы, хяналт тавих;


3.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3 Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

БЛХАГВАМАНДАЛ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны
өдрийн 23 дугаар тогтоолын хавсралт



Актлах хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Данснаас хасах болсон шалтгаан
1	50 садны хашаа	2013.12.31		1	14,325,176.15	14,325,176.15	2,671,759.04	11,653,417.11	Тус сад, явган хүний замыг
2	Явган хүний зам	2013.12.31	m ²	1,143	26,512.92	30,307,696.56	5,808,975.17	24,498,721.39	
3	Дүн				44,632,872.71 /дечин дөрвөн сая зургаан зуун гучин хоёр мянга найман зуун далан хоёр төгрөг далан нэгэн мөнгө/	8,480,734.21	36,152,138.50 /гучин зургаан сая нэг зуун тавин хоёр мянга нэг зуун гучин найман төгрөг тавин мөнгө/	шинэ зураг төсөвөөр тохижуулан хийхээр тендэр зарлагдан, ажил эхлэхээр болсон.	